



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/041/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмааы Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор А.Пүрэвцэцэг Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

ЦЭНХЭР СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.БАТЦЭЦЭГ ТАНАА

№ _____
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цэнхэр сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журам, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж батлаагүй, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2,979.0 мянган төгрөгийг хоолны зардалд зориулалт бус зарцуулсан байна.
- Бараа материалын зарцуулалтын анхан шатны бүрдүүлэлт хангалтгүй, тулган шалгах боломжгүй.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын 2.5-д “Төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хурлын байгууллагын төсөвт зардлын хүрээнд тооцон төлөвлөж, хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн сонгууль зохион байгуулагдаж 25 хурлын төлөөлөгч нар шинээр сонгогдсон байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийт 3 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 220,331.1 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэл 91.2 хувь буюу 201,099.8 мянган төгрөг байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний 23 арга хэмжээ 100-90 хувийн хэрэгжилттэй, 14 арга хэмжээ 70-80 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй нийт арга хэмжээний хэрэгжилт дунджаар 93.7 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,826,000.00</u>	<u>5,051,000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	3,826,000.00	5,051,000.00
351	Түүхий эд материал	2,503,700.00	3,383,700.00
35110	Тусгай зориулалттай материал	2,503,700.00	3,383,700.00
354	Хангамжийн материал	1,322,300.00	1,667,300.00
35410	Бичиг хэргийн материал	342,300.00	1,419,300.00
35420	Аж ахуйн материал	230,000.00	248,000.00
35470	Бусад хангамжийн материал	750,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,829,151.43</u>	<u>17,658,220.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,829,151.43	17,658,220.13
392	Биет хөрөнгө	22,879,151.43	17,133,220.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,256,433.00	30,256,433.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,884,627.22)	(18,910,270.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,522,064.00	14,525,791.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,048,768.32)	(8,772,783.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,344,109.00	844,129.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,310,059.03)	(810,079.03)
393	Биет бус хөрөнгө	950,000.00	524,999.96
39301	Програм хангамж	950,000.00	950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(425,000.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>27,655,151.43</u>	<u>22,709,220.13</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>27,655,151.43</u>	<u>22,709,220.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	27,655,151.43	22,709,220.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,646,000.00	5,646,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	21,946,408.12	17,000,476.82
51210	Өмнөх үеийн үр дүн	21,946,408.12	21,946,408.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,945,931.30)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,743.31	62,743.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>27,655,151.43</u>	<u>22,709,220.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,316,800.00	220,331,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,316,800.00	220,331,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,316,800.00	220,331,100.00

Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,316,800.00	220,331,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	140,982,476.98	225,277,031.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,982,476.98	225,277,031.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,306,417.51	195,735,097.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,402,233.62	124,134,909.34
210101	Үндсэн цалин	52,939,023.22	68,913,552.74
210102	Нэмэгдэл	20,733,656.06	42,928,668.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,873,690.00
210104	Урамшуулал	3,729,554.34	7,418,998.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,672,290.91	15,557,613.10
210201	Тэтгэврийн даатгал	6,578,762.36	10,659,604.10
210202	Тэтгэмжийн даатгал	773,972.03	1,194,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	619,178.23	887,422.20
210204	Ажилгүйдлийн даатгал	152,434.19	280,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,547,944.10	2,535,494.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,258,530.00	7,534,041.00
210401	Бичиг хэрэг	891,700.00	2,895,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,998,030.00	2,889,046.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	776,500.00	380,000.00
210404	Ном, хэвлэл	214,000.00	372,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	317,500.00	997,995.00
2107	Томилолт, зочны зардал	354,000.00	1,248,000.00
210702	Дотоод албан томилолт	354,000.00	1,248,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,702,686.00	37,066,342.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,504,350.00	36,848,556.64
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,936.00	123,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,916,676.98	10,194,191.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	425,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,592,000.00	3,598,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,324,676.98	6,170,931.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	10,310,653.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,310,653.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,110,653.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,676,059.47	19,231,280.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,676,059.47	19,231,280.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>6,334,323.02</u>	<u>(4,945,931.30)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>6,334,323.02</u>	<u>(4,945,931.30)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>147,316,800.00</u>	<u>220,331,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,316,800.00	220,331,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,316,800.00	220,331,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,316,800.00	220,331,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>147,316,800.00</u>	<u>220,331,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,316,800.00	220,331,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,640,740.53	190,789,166.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,402,233.62	124,134,909.34
210101	Үндсэн цалин	52,939,023.22	68,913,552.74
210102	Нэмэгдэл	20,733,656.06	42,928,668.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,873,690.00
210104	Урамшуулал	3,729,554.34	7,418,998.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,672,290.91	15,557,613.10
210201	Тэтгэврийн даатгал	6,578,762.36	10,659,604.10
210202	Тэтгэмжийн даатгал	773,972.03	1,194,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	619,178.23	887,422.20
210204	Ажилгүйдлийн даатгал	152,434.19	280,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,547,944.10	2,535,494.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,453,830.00	9,000,041.00
210401	Бичиг хэрэг	1,087,000.00	4,229,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,998,030.00	2,889,046.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	776,500.00	380,000.00
210404	Ном, хэвлэл	214,000.00	504,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	317,500.00	997,495.00
2107	Томилолт, зочны зардал	354,000.00	1,248,000.00
210702	Дотоод албан томилолт	354,000.00	1,248,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,992,386.00	36,410,342.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,794,050.00	36,192,556.64
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,936.00	123,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,766,000.00	4,438,260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	800,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,766,000.00	3,638,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,676,059.47	29,541,933.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,310,653.00

Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,110,653.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,676,059.47	19,231,280.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,676,059.47	19,231,280.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	15,612,085.10	21,320,828.41
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	15,612,085.10	21,320,828.41
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,334,323.02	6,334,323.02
4	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	21,946,408.12	27,655,151.43
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	21,946,408.12	27,655,151.43
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
7	Тайлант үеийн үр дүн			-4,945,931.3	-4,945,931.3
8	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,646,000.00	62,743.31	17,000,476.82	22,709,220.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	220,331,100.00	201,099,819.08	19,231,280.92	91.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,331,100.00	201,099,819.08	19,231,280.92	91.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,549,100.00	190,789,166.08	18,759,933.92	91.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,096,100.00	124,134,909.34	15,961,190.66	88.61
210101	Үндсэн цалин	140,096,100.00	68,913,552.74	71,182,547.26	49.19
210102	Нэмэгдэл	-	42,928,668.10	(42,928,668.10)	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,873,690.00	(4,873,690.00)	
210104	Урамшуулал	-	7,418,998.50	(7,418,998.50)	

Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,512,000.00	15,557,613.10	1,954,386.90	88.84
210201	Тэтгэврийн даатгал	11,908,100.00	10,659,604.10	1,248,495.90	89.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,401,000.00	1,194,892.00	206,108.00	85.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,120,800.00	887,422.20	233,377.80	79.18
210204	Ажилгүйдлийн даатгал	280,200.00	280,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,801,900.00	2,535,494.80	266,405.20	90.49
2104	Хангамж, бараа материалын зардал	9,225,000.00	9,000,041.00	224,959.00	97.56
210401	Бичиг хэрэг	4,230,000.00	4,229,500.00	500.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	2,891,000.00	2,889,046.00	1,954.00	99.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	380,000.00	220,000.00	63.33
210404	Ном, хэвлэл	504,000.00	504,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	997,495.00	2,505.00	99.75
2107	Томилолт, зочны зардал	1,416,000.00	1,248,000.00	168,000.00	88.14
210702	Дотоод албан томилолт	1,416,000.00	1,248,000.00	168,000.00	88.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,850,000.00	36,410,342.64	439,657.36	98.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,600,000.00	36,192,556.64	407,443.36	98.89
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	64,350.00	15,650.00	80.44
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	123,436.00	16,564.00	88.17
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,450,000.00	4,438,260.00	11,740.00	99.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	800,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,650,000.00	3,638,260.00	11,740.00	99.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,782,000.00	10,310,653.00	471,347.00	95.63

Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	10,782,000.00	10,310,653.00	471,347.00	95.63
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	9,110,653.00	471,347.00	95.08
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	220,331,100.00	239,562,380.92	(19,231,280.92)	108.73
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	220,331,100.00	239,562,380.92	(19,231,280.92)	108.73
132001	Орон нутгийн төсвөөс	220,331,100.00	239,562,380.92	(19,231,280.92)	108.73
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулаагүй 2,979.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5.1 АЛБАН ШААРДЛАГА

5.1.1 Бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримт руу тулган шалгах боломжгүй, эд хариуцагчийн тайланг бүрэн гаргаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй бөгөөд завсрын аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөх нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.9-д "Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

5.1.2 Иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж батлаагүй, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2,979,000 төгрөгийг хоолны мөнгөнд шилжүүлэн зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмын 2.5-д Төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах тээврийн болон бусад зардлыг санхүүжүүлэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан эдийн засгийн ангиллын дагуу тухайн хурлын байгууллагын төсөвт зардлын хүрээнд тооцон төлөвлөж, хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Завсрын аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	0							1			
Төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан	1	2,979.0			1	2,979.0						
Дүн	2	1895.6			1	2,979.0			1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн							0	